

ТӨСӨЛ

**ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВЭР ЗУУЧЛАЛЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1. Энэхүү журмын зорилго нь төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагааг зохицуулах, үйлчилгээний чанарыг сайжруулах, үйлчлүүлэгч, тээвэр зуучлагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, хяналт тавих арга замыг тогтооход оршино.
2. Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно. Үүнд:
 - 2.1 **Төмөр замын тээвэр зуучлалын үйлчилгээ** – Төмөр замын ачаа тээвэрлэлтийг зохион байгуулах, ачааг тээвэрлэх гэрээ байгуулах, илгээлтийг гүйцэтгэх ба ачааг хүлээн авах, түүнчлэн ачаа тээвэрлэхтэй холбоотой бусад үйлчилгээ,
 - 2.2 **Төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагаа** – Ачаа илгээгчээс ачаа хүлээн авагч хүртэл тээвэр зуучлалын үйлчилгээг гэрээний нөхцөл шаардлагын дагуу явуулах үйл ажиллагаа,
 - 2.3 **Төмөр замын тээвэр зуучлагч** –
 - 2.4 **Үйлчлүүлэгч** – Тээвэр зуучлагчтай тээвэр зуучлалын гэрээ байгуулж, тээвэр зуучлалын үйлчилгээний төлбөрийг төлөх үүрэг хүлээсэн этгээд,
 - 2.5 **Тээвэр зуучлалын гэрээ** – Тээвэр зуучлалын үйлчилгээ үзүүлэхээр тээвэр зуучлагч, үйлчлүүлэгч хооронд байгуулсан гэрээ,
 - 2.6 **Ачаа** – Тээвэр зуучлалын үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу тээвэр зуучлагчийн тээвэрлэлтийг нь зохион байгуулж буй эд зүйлс,
 - 2.7 **Ачаа илгээгч** – Ачааг тээвэр зуучлагчид тээвэрлүүлэхээр хүлээлгэн өгсөн этгээд,
 - 2.8 **Ачаа хүлээн авагч** – Тээвэрлэлтийг гүйцэтгэж дууссаны дараа тээвэр зуучлагчаас ачааг хүлээн авахаар эрх олгогдсон этгээд,
 - 2.9 **Тээвэрлэгч** – Тээвэрлэлтийн гэрээний үндсэн дээр ачаа тээвэрлэлтийг гүйцэтгэж буй этгээд.
3. Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тээвэр зуучлалын үйл ажиллагааг бодлогоор зохицуулах, холбогдох хууль журмын дагуу гэрчилгээжүүлэх, үйл ажиллагаанд хяналт тавих ажлыг хариуцна.
4. Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэхүү журмын 3 дахь заалтыг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль журамд заасан шаардлагад нийцүүлэх, нээлттэй, ил тод, шударга өрсөлдөөнийг хангах, үйлчилгээний чанарыг сайжруулах зарчмыг баримтална.

Commented [m1]: Хариуцна гэдгийг яаж өөрөөр тодорхойлж болох вэ?

Commented [m2]: ?

**ХОЁРДУГААР БҮЛЭГ
ТЭЭВЭР ЗУУЧЛАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ**

5. Тээвэр зуучлагч ба ~~ачаа илгээгч, хүлээн авагчийн үйлчлүүлэгчийн~~ хоорондын харилцаа нь тэдгээрийн хооронд байгуулсан гэрээгээр зохицуулагдана.
6. Тээвэр зуучлагч ба тээвэрлэгчийн хоорондын харилцаа нь тэдгээрийн хооронд байгуулсан тээврийн гэрээгээр зохицуулагдана.
7. Тээвэр зуучлагч нь үйлчлүүлэгчид дараах үйлчилгээг үзүүлнэ.
 - 7.1 Ачааг ~~илгээгчөө ачааг үйлчлүүлэгчээс~~ хүлээн авах, тээвэрлэлтэд бэлтгэх, тээвэрлүүлэхээр тээвэрлэгчид хүлээлгэн өгөх, хүлээн авагчид олгох.
 - 7.2 Тээврийн баримт бичгийг бүрдүүлэх
 - 7.3 Ачааны хаяг солих **баримт бичгийг бүрдүүлэх**
 - 7.4 Үйлчлүүлэгчийг төлөөлж тээвэрлэгчтэй тээврийн хөлсний тооцоог хийх
 - 7.5 Ачаа илгээгч, хүлээн авагчид ачааны тээвэрлэлтийн явцын талаар мэдээллийн үйлчилгээ үзүүлэх
 - 7.6 Ачааг гаалийн **байгууллагад мэдүүлэх**, гаалийн мэдүүлэгтэй холбоотой асуудлаар зөвлөгөө өгөх
 - 7.7 Ачааны гаалийн мэдүүлэг болон дагалдах бичиг **баримтыг бичгийг бүрдүүлэх**
 - 7.8 Ачааны даатгалын үйлчилгээ үзүүлэх
 - 7.9 Ачааг гаалийн баталгаат агуулах, агуулахад хадгалах
 - 7.10 Бусад үйлчилгээ
8. Тээвэр зуучлагч нь энэ журмын 7-д заасан үйлчилгээг үзүүлэхдээ Монгол Улсын холбогдох хууль, тогтоомж, дүрэм журам, стандарт, Монгол Улсын олон улсын гэрээг мөрдөх ба аюулгүй, хурдан шуурхай үйлчлэх зарчмыг баримтална.

ГУРАВДУГААР БҮЛЭГ
ТЭЭВЭР ЗУУЧЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧ БАЙГУУЛЛАГАД
ТАВИГДАХ ШААРДЛАГА

9. Төмөр замын тээвэр зуучлагч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - 9.1 Тээвэр зуучлагч нь ...-аас доошгүй сая төгрөгийн өөрийн хөрөнгө буюу дүрмийн сан бүхий Монгол улсын хуулийн этгээд байна.
 - 9.2 Монополь шинжтэй тээвэрлэгч байгууллага нь тээвэрлэгч болон бусад шударга бус өрсөлдөөн үүсгэх эрсдэлтэй хуулийн этгээд тээвэр зуучлалын үйл ажиллагаа эрхэлж буй тохиолдолд тээврийн болон тээвэр зуучлагчийн үйл ажиллагааны санхүүгийн тооцоо нь тусдаа байна.
 - 9.3 Тогтвортой гадаад худалдааны ачаа тээврийн зах зээлийн эх үүсвэртэй байна.
 - 9.4 Тээврийн менежмент, гадаад худалдааны чиглэлийн мэргэжилтэй ажилтантай, ажилтан нь тухайн чиглэлээр дадлага туршлагатай байна.

Commented [m3]: Ачааны хаяг солих

Commented [m4]: Байгууллагад мэдүүлэх гэж хэллэгийг нь тодруулья

Commented [m5]: 7.6, 7.7 хооронд нийлүүлэх үү

- 9.5 Үйл ажиллагаа явуулах байр буюу албан тасалгаатай байх бөгөөд өөрийн эзэмшлийн бол үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, түрээсэлдэг бол түрээсийн гэрээтэй байна.
- 9.6 Тээвэр зуучлагч нь ачааг хүлээн авах, хүлээлгэн өгөх, ачиж буулгах, хадгалах, савлах боох зориулалттай өөрийн эзэмшлийн болон түрээсийн, эсвэл ашиглалтын гэрээтэй терминалтай байж болох бөгөөд терминал нь холбогдох стандартын шаардлагыг хангасан, зохих журмын дагуу гэрчилгээ авсан байна.
- 9.7 Тээвэр зуучлалын үйл ажиллагаанд тавигдах бусад Монгол Улсын хууль тогтоомж, стандартын шаардлага, олон улсын гэрээний шаардлагыг хангасан байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
ТЭЭВЭР ЗУУЧЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

10. Тээвэр зуучлагч нь дараах эрхтэй. Үүнд:

- 10.1 Үйлчлүүлэгчтэй байгуулсан [тээвэр зуучлалын](#) гэрээний нөхцөлийн дагуу тээврийн хөлс болон үйлчилгээний төлбөрийг үйлчлүүлэгчээс авах,
- 10.2 Үйлчлүүлэгчээс ачааны шинж чанар, тээвэрлэх нөхцөл зэрэг тээвэр зуучлалын ажиллагааг гүйцэтгэхтэй холбоотой үнэн зөв [мэдээллийг мэдээлэл шаардаж авах.](#)
- 10.3 Үйлчлүүлэгчийн ачааг ачаа хүргэх хугацаанд аюулгүй, найдвартай тээвэрлэхийг тээвэрлэгчээс шаардах.

11. Тээвэр зуучлагч нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- 11.1 Үйлчлүүлэгчтэй байгуулсан гэрээний нөхцөлийн дагуу тээвэр зуучлалын үйл ажиллагааг гүйцэтгэх,
- 11.2 Үйлчлүүлэгчийг илгээлтийн төрөл болон ачаа тээвэрлэх замнал, ачааны байршлын талаарх мэдээллээр хангах,
- 11.3 Давагдашгүй хүчин зүйлээс бусад шалтгаанаар ачааг ачаа хүлээн авагчид хүлээлгэн өгөх хугацааг хойшлуулахгүй байх,
- 11.4 Тээвэрлэгчтэй байгуулсан тээврийн гэрээний нөхцөлийн дагуу тээврийн хөлсний тооцоог цаг тухайд нь хийж барагдуулах,
- 11.5 Тээвэрлэлтийн явцад ачаа дутсан, гэмтсэн, алга болсон тохиолдолд Төмөр замуудын хамтын ажиллагааны байгууллагын “Олон улсын ачааны харилцааны хэлэлцээр” болон холбогдох акт, гомдол барагдуулах журмын дагуу үйлчлүүлэгчийн хохирлыг барагдуулах,
- 11.6 Төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн тогтоосон хугацаанд үйл ажиллагааны тайлангаа өгөх,
- 11.7 Үйл ажиллагааны гэрчилгээн дээрх мэдээлэл өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүрт төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэж бүртгүүлэх,
- 11.8 Зуучлагч нь тээвэр зуучлалын гэрээний дагуу тээвэр зуучлалын үйлчилгээ үзүүлэх явцад үйлчлүүлэгчийн шаардлагыг биелүүлэх үүрэгтэй. Зуучлагч

нь үйлчлүүлэгчийн шаардлагыг дараах тохиолдолд биелүүлэхгүй байж болно. Үүнд:

- 11.8.1 Үйлчлүүлэгчийн эрх ашигт нийцэхгүй гэж үзсэн,
 - 11.8.2 Шаардлагыг биелүүлэх боломжгүй тухай мэдэгдлийг тээвэр зуучлалын гэрээнд заасан нөхцөлийн дагуу өөрөөс шалтгаалаагүй нөхцөл байдлын улмаас үйлчлүүлэгчид урьдчилан мэдэгдээгүй,
 - 11.8.3 Шаардлагыг биелүүлэх боломжгүй тухай мэдэгдлийн хариуг үйлчлүүлэгчээс 1 хоногийн дотор ирүүлээгүй.
- 11.9 Тээвэр зуучлалын үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгж нь үйл ажиллагааны хариуцлагын даатгалд хамрагдсан байна.

ТАВДУГААР БҮЛЭГ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

12. Үйлчлүүлэгч нь дараах эрхтэй. Үүнд:

- 12.1 Илгээлтийн төрөл болон тээврийн замналыг сонгох,
- 12.2 Тээвэр зуучлагчтай байгуулсан гэрээнд заасан хугацааны дагуу ачааг хүлээлгэн өгөх, хүлээн авах,
- 12.3 Ачааны тээврийн замын мэдээ болон холбогдох бусад мэдээллийг авах,
- 12.4 Тээвэрлэлтийн явцад ачааны бүрэн бүтэн байдал алдагдсан, гэмтсэн, дутсан нь тогтоогдвол холбогдох дүрэм, журмын дагуу хохирлоо нэхэмжлэх.

13. Үйлчлүүлэгч нь дараах үүрэгтэй. Үүнд:

- 13.1 Тээвэр зуучлагчид ачааг хүлээлгэн өгөхдөө тээвэрлэлтэд шаардлагатай ачааны талаарх бүх мэдээллийг үнэн зөв мэдүүлэх,
- 13.2 Тээвэр зуучлагчтай байгуулсан гэрээний нөхцөлийн дагуу тээврийн хөлс болон үйлчилгээний хөлсийг тээвэр зуучлагчид төлж барагдуулах.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ ЗУУЧЛАЛЫН БИЧИГ, БАРИМТ

14. Зуучлалын бичиг баримтад дараах баримт бичиг хамаарна. Үүнд:

- 14.1 Зуучлалын даалгавар /Тээвэр зуучлалын гэрээний хүрээнд зуучаас үйлчлүүлэгчид үзүүлэх тээвэр зуучлалын үйлчилгээний нөхцөл, жагсаалтыг тодорхойлно./,
- 14.2 Зуучлалын падаан /Зууч нь үйлчлүүлэгч эсвэл түүний заасан ачаа илгээгчээс ачааг тээвэрлэлтэд хүлээн авсан тухай нотолгоо/,
- 14.3 Агуулахын падаан /Зуучийн үйлчлүүлэгчээс ачааг агуулахад хадгалахаар хүлээн авсан тухай нотолгоо./.

15. Тээвэр зуучлалын үйлчилгээний төрөл, нөхцөлөөс хамаараад дотоодын болон олон улсын харилцааны ачаа тээвэрлэлтэд тээвэр зуучлалын гэрээний талууд хоорондоо энэхүү Дүрмийн 5 дугаар зүйлд зааснаас бусад зуучийн бичиг баримт ашиглаж болно.
16. Зуучийн бичиг баримт нь Тээвэр зуучлалын гэрээний салшгүй нэг хэсэг байна. Зуучийн бичиг баримтыг бичгээр үйлдэнэ. Зуучлалын бичиг баримтын загвар болон тэдгээрийг хэрхэн бүрдүүлэх журмыг Хавсралтаар батална.
17. Үйлчлүүлэгч нь зуучлалын даалгаврыг бөглөж, баталгаажуулан зуучид хүлээлгэн өгнө. Зуучийн даалгавар нь ачааны шинж чанар, түүний тэмдэглэгээ, жин, хэмжээ болон байрын тооны талаар үнэн зөв, бүрэн мэдээллийг агуулсан байна. Зуучийн даалгаврыг үйлчлүүлэгч нь Тээвэр зуучлалын гэрээгээр өөрөөр заагаагүй бол цаасаар зуучид гаргаж өгнө.
18. Тээвэр зуучлагч нь зуучлалын даалгаврыг Тээвэр зуучийн гэрээгээр тогтоосон хугацаанд судлан үзэж Тээвэр зуучлалын үйлчилгээ үзүүлэхийг зөвшөөрөх эсвэл татгалзаж, түүний шалтгааны хамт үйлчлүүлэгчид хүргүүлнэ.
19. Үйлчлүүлэгч зуучаас зуучлалын даалгаврыг зөвшөөрсөн тухай нотолгоог хүлээн авсан хугацаанаас эхлэн зуучлалын даалгаврыг хэрэгжүүлнэ. Тээвэр зуучлалын гэрээг хэрэгжүүлэх аль ч шатанд Үйлчлүүлэгч нь өмнө өгсөн зуучлалын даалгаврыг гүйцэтгэхэд зарцуулсан бодит зардлыг барагдуулсны үндсэн дээр даалгаврыг буцаах эрхтэй. Зуучлалын даалгавар буцаах хүсэлтийг бичгээр гаргана.
20. Зуучлалын даалгавар болон түүнийг буцаах хүсэлтийг факсаар болон цахим шуудангаар гаргах нөхцөлийг тээвэр зуучлалын гэрээгээр тодорхойлно.
21. Зуучлалын падааныг зууч нь ачааг хүлээн авах үед үйлчлүүлэгчид олгох бөгөөд энэхүү баримт бичиг нь тээвэрлэлтийг дуусган үйлчлүүлэгчид эсвэл түүний заасан ачаа хүлээн авагчид ачааг хүлээлгэн өгөх хүртэлх хугацаанд ачааг эзэмших эрхийг зуучлагчид олгоно.
22. Үйлчлүүлэгчийн ачааг агуулахад хадгалахаар хүлээн авахдаа тээвэр зуучлагч нь агуулахын падааныг үйлчлүүлэгчид олгоно.
23. Хэрэв тээвэр зуучлалын гэрээнд өөрөөр заагаагүй бол тээвэр зуучлагч нь ачаа тээвэрлэлтийг зохион байгуулахдаа шаардлагатай тохиолдолд дараах ажиллагааг гүйцэтгэнэ. Үүнд:
 - 23.1 Ачааг тээвэрлэх, хадгалах, тээврийн нэг төрлөөс нөгөө төрөлд шилжүүлэх болон тээвэрлэлтийг гүйцэтгэхэд шаардлагатай бусад асуудлыг тээвэрлэгчидтэй тохиролцох,
 - 23.2 Тээвэрлэлтийг гүйцэтгэхэд шаардлагатай гаалийн болон бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх.
24. Үйлчлүүлэгчийн болон өөрийн нэрийн өмнөөс тээвэрлэгчтэй ачаа тээвэрлэлтийн тооцоог хийх.
 - 24.1 Үйлчлүүлэгчийн шаардлагаар тээвэр зуучлагч нь дараах мэдээллийг гаргаж өгнө. Үүнд:
 - 24.2 Байгууллагын бүтэн нэр болон хаяг байршил /хуулийн этгээд бол/, Нэр болон оршин суугаа гэрийн хаяг /бие дааж үйл ажиллагаа эрхлэгч бол/,

- 24.3 Тээвэр зуучлалын үйлчилгээ нь тогтоосон шаардлагад нийцэж байгаа баталгааны тухай мэдээлэл,
- 24.4 Зуучлагчийн үзүүлж буй тээвэр зуучлалын үйлчилгээний жагсаалт, тэдгээрийн үнэ,
- 24.5 Тээвэр зуучлалын үйлчилгээний төлбөр хийх нөхцөлийн тухай мэдээлэл,
- 24.6 Ачааг бусад төрлийн тээврээр тээвэрлэх үнэ, нөхцөл, дүрмийн талаарх мэдээлэл,
- 24.7 Тодорхой ачааны төрлийг төрөл бүрийн тээврээр тээвэрлэх, зохион байгуулахтай холбоотой бусад мэдээлэл.
25. Тээвэр зуучлалын гэрээнд заасан тохиолдолд хүрэх өртөөнд тээвэрлэгчээс ачааг хүлээн авах үед тээвэр зуучлагч нь шаардлагатай бичиг баримт бүрдүүлэлтэд оролцоно.
26. Зуучлагч нь аюултай, түргэн муудах болон бусад тээвэрлэлтийн тусгай нөхцөл шаардах ачааг үйлчлүүлэгчээс гагцхүү тэдгээрийг тээвэрлэх нөхцөлийн тухай мэдээллийг бичгээр ирүүлсэн тохиолдолд хүлээн авна.
27. Зуучлагчийн үзүүлж буй тээвэр зуучлалын үйлчилгээний чанар нь МУ-ын үндэсний стандарт, тээвэр зуучлалын үйл ажиллагааны салбар дахь норматив баримт бичиг болон тээвэр зуучлалын гэрээнд заасан нөхцөлүүдийн шаардлагад нийцсэн байна.

ДОЛДУГААР БҮЛЭГ ТЭЭВЭР ЗУУЧЛАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНД ТАВИХ ХЯНАЛТ

28. Тээвэр зуучлалын үйлчилгээнд захиргааны хяналт тавих ажлыг тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.
29. Тээврийн асуудал эрхэлсэн Монгол Улсын сайдын /цаашид Сайд гэх/ тушаалаар байгуулсан байнгын, орон тооны бус Ажлын хэсэг тээвэр зуучлалын үйл ажиллагаа нь тээвэр зуучлалын үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээний нөхцөл, шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянан шалгаж холбогдох журмын дагуу гэрчилгээ олголт, сунгалт, түдгэлзүүлэхтэй холбоотой дүгнэлт гаргана.
30. Сайд ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн гэрчилгээ олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгохыг шийдвэрлэнэ.
31. Тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тээвэр зуучлалын үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн үйлчилгээний чанарыг сайжруулах, нийгэм эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор тэдгээрийн үйл ажиллагаанд жил бүр явцын дүгнэлт хийнэ. Жилийн явцын дүгнэлтийг нь дараах байдлаар гаргана:
- 31.1 Тээвэр зуучлалын үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж нь жил бүрийн 3 дугаар сарын 30-наас өмнө Тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад өнгөрсөн жилийн үйл ажиллагааны тайлангийн хүснэгтийг ирүүлэх бөгөөд үүнд өнгөрсөн жилд нийт зуучилсан ачааны хэмжээ, орлого, төлсөн татвар зэрэг мэдээллийг багтаасан байна. Шаардлагатай бол

Commented [m6]: Давталт болох үү?

Commented [m7]: Нөгөө тушаал

татварын алба, тээвэрлэгч байгууллагын тодорхойлолтыг хавсаргана. Тайлангийн маягтын загварыг уг журмын хавсралтаар батална.

- 31.2 Ажлын хэсэг тайланг үндэслэн тухайн ~~тээвэр зуучлалын үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжийн тээвэр зүүчлагчийн~~ өмнөх жилийн үйл ажиллагаанд дүгнэлт хийнэ.
- 31.3 Хангалттай дүгнэгдсэн тохиолдолд гэрчилгээн дээр жилийн явцын шалгалтад тэнцсэн тухай тэмдэглэл, хангалтгүй дүгнэгдсэн тохиолдолд тэнцээгүй тухай тэмдэглэл хийж Улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлнэ.
- 31.4 Тээвэр зуучлалын үйл ажиллагаа эрхлэгч нь гэрчилгээний хүчинтэй хугацаанд дараалан 2-оос дээш удаа явцын шалгалтад хангалтгүй дүгнэгдсэн тохиолдолд Ажлын хэсэг гэрчилгээг хүчингүй болгуулах тухай дүгнэлтийг тээврийн асуудал эрхэлсэн Монгол Улсын сайдад танилцуулж шийдвэрлүүлнэ.